



ПАУЭР БЛАСТ ХХК

**Өмнөговь аймаг, Гурван тэс сум,
“ТМ-19” тэсрэх бодисын үйлдвэр,
агуулах төслийн 2023 оны байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

ХЯНАСАН: БОАЖ ЯАМНЫ ХБОБНУ ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН:/П.ШИНЭЦЭЦЭГ/

БОЛОВСРУУЛСАН: “ПАУЭР БЛАСТ” ХХК “ТМ-19” ҮЙЛДВЭРИЙН

ХАБЭАБО АХЛАХ АЖИЛТАН:/Н.ЛХАГВА-ОЧИР/

Агуулга

1. Төслийн товч танилцуулга.....	1
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	14
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....	17
4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	23
6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
8. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	25
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	34
10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	36
11.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	38
12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь...	43

1. ТМ-19 үйлдвэрийн Төслийн тодорхойлолт

Төслийн зорилго

1.1 Пауэр Бласт компанийн тэсэлгээний ажил үйлчилгээг удаан хугацаанд, тогтвортой авч буй гэрээт компанийн уурхайн дэргэд бага овор, бага хүчин чадлын, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, бүрэн автоматжуулагдсан, эрүүл аюулгүй ажиллах орчинг бүрдүүлсэн, хог хаягдалгүй орчин үеийн дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг байгуулж, тэсрэх бодисын үл тэсрэх хольц буюу эмульсийг үйлдвэрлэн, түүнийгээ цооног цэнэглэх тусгай зориулалтын автомашинаар усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодис болгон уурхайн цооногт газар дээр нь гүйцээн үйлдвэрлэх давуу талыг бий болгох, чанартай тэсрэх бодисоор хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг цаг тухайд нь найдвартай хангах зорилготой.

Цар хүрээ, хэмжээ

Төслийн нэр: Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр


Төсөл хэрэгжүүлэх байгууллага: “Пауэр Бласт” ХХК

Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар: 5455979, 9011260038

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион билдинг, А блок, 12-р давхар, 1205 тоот

Төслийн байршил: Үйлдвэр нь Өмнөговь аймгийн Гурвантэс сум, Урт багийн нутаг дэвсгэрт, уул уурхайн бүсэд байрладаг. Гурван тэс сумын төвөөс 37 км, “Өсөх зоос” ХХК-ийн ажилчдын байрлах кемпээс 1.5 километрын зайтай, Улаанбаатараас 950 км-т, манай томоохон хэрэглэгчийн уурхайгаас 6.5-7 км, Хилийн боомт болох Шивээхүрэнгийн боомтоос 45 км-т байрлана. Үйлдвэр нь 3 га-д үйл ажиллагаа явуулна.

Зураг 0.1 Төслийн талбайн байршил



Төсөл хэрэгжүүлэх үе шат

“Пауэр Бласт” ХХК нь Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас олгосон “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх” тусгай зөвшөөрлийн хүрээнд үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх, тэсрэх материал импортлох, худалдах, хадгалах, тээвэрлэх, тэсэлгээний ажил үйлчилгээ үзүүлэх, тэсэлгээний цооног өрөмдлөх чиглэлээр 2011 оноос эхлэн тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн эхний үе шатанд Хүрэн шанд төслийн тэсрэх бодисын хэрэглээг хангахар төлөвлөсөн. Цаашлаад Гурвантэс сумын уул уурхайн бүсд байгаа уурхайнууд тэсрэх бодисын хэрэглээг эсвэл тухайн бүсэд өсөн нэмэгдэх хэрэглээг ч нийлүүлэх боломжтой гэж үзэж байна.

Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ

Тус компани нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрлах Хүрэншандын нүүрсний орд газарт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Өсөх зоос” ХХК, Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг, Баруун ноён уулын нүүрсний орд газар байрлах “Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн нүүрсний ил уурхайнуудад тэсэлгээний ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид тэдгээрийн тэсэлгээний ажлын хэмжээ нэмэгдэж, түүнийг даган хэрэглэх тэсрэх бодисын хэмжээ өсөхөөр байна. Уурхайн талбайд тэсэлгээ хийхээр өрөмдсөн цооногуудын

70-аас дээш хувь нь устай гарч байгаа тул усанд тэсвэртэй тэсрэх бодис шаардагдаж байна.

Өнөөдрийн байдлаар тэсрэх бодис импортлох замаар энэ хэрэгцээг хангаж байгаа бөгөөд, тээвэрлэх, хадгалахад ихээхэн хэмжээний нэмэлт зардал гарч, үйл ажиллагааны бэрхшээл тулгарч байна. Мөн тэсэлгээний цооногийг цэнэглэх ажлыг гар аргаар гүйцэтгэж байгаа нь өсөн нэмэгдэж байгаа тэсэлгээний ажлын хурдыг гүйцэхгүйд хүрч байгаа учир түүнийг механикжуулах зайлшгүй шаардлага гарч байна.

Түүхий эд, үйлдвэрлэлт ашиглалт

Үндсэн түүхий эд

Үйлдвэр нь эмульсийн тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох үл тэсрэх хольц буюу эмульс болон бусад үл тэсрэх нэмэгдлүүдийг үйлдвэрлэхэд хэд хэдэн химийн бодисуудыг үндсэн болон нэмэгдэл орцоор ашигладаг. Тэдгээр химийн бодисуудын сарын болон жилийн хэрэглээг дараах хүснэгтэд үзүүлбэл: (Хүснэгт 4.1).

Химийн бодисын хэрэглээ

Хүснэгт №0

№	Түүхий эд, бодисын нэрс	1 Сарын хэрэглээ, тн	1 жилийн хэрэглээ, тн
1	Аммиакийн шүү /гялгар/	667.53	8,010.34
2	Ус	103.39	1,240.73
3	Эмульгатор	8.50	102.05
4	Үйлдвэрийн тос	34.02	408.20
5	Натрийн нитрит	1.73	20.71
6	Сульфамины хүчил	0.26	3.15
7	Тиомочевин	0.26	3.15
8	Уротропин	0.26	3.15
9	Этиленгликоль	4.72	56.70
10	Тиоцианит натри	0.08	0.99
11	Цууны хүчил	0.90	10.85

Аммиакийн шүү: Эмульс бэлтгэхэд кальц болон магнийн нэмэгдэлтэй “А” эсвэл “Б” маркийн, гадаргуун идэвхит бодис ба тослог агуулсан нэмэгдэлгүйгээр бэлтгэгдсэн аммиакийн шүүг исэлдүүлэгч халуун уусмалын үндсэн түүхий эд болгон ашиглана. Аммиакийн шүү нь хүчтэй исэлдүүлэгчийн ангилалд хамаарна. Аммиакийн шүү нь усанд амархан уусдаг ба уусгалтын процесс нь температураас ихээхэн хамаарна. Аммиакийн шүүг усанд уусгахад их хэмжээний дулаан шингээн уусдаг бөгөөд уусалтын дулаан багтаамж нь 330 кДж/кг байна. Температур нэмэгдэхэд шүүний уусалт ихэснэ. Аммиакийн шүүний физик-химийн үзүүлэлт нь ГОСТ 2-2013 стандартын үзүүлэлтийн хангасан байна.

Аммиакийн шүүг хэвийн нөхцөлд хадгалахад химийн тогтвортой. Уусмал, хайлмал хэлбэрт байхдаа аммиакийн шүү нь зэс, цайр, хар тугалга зэрэг олон төрлийн металл болон тэдгээрийн хайлштай урвалд орж нитратын давс үүсгэнэ. Чийглэг шүү эдгээр металлыг зэврүүлэх ба хайлмал эсвэл хатуу шүү нь хөнгөн цагаан болон түүний хайлш, хром ба никелээр бүрсэн ган зэрэгтэй үйлчлэлд ордоггүй.

Аммиакийн шүүний исэлдүүлэгч халуун уусмалыг ашиглан үйлдвэрлэл явуулдаг тоног төхөөрөмжийг зэвэрдэггүй ган болон хөнгөн цагааны хайлшаар хийнэ.

Аммиакийн шүү нь механик үйлчлэлд мэдрэмж багатай ба температурын өсөлт, органик бодисын үйлчлэлийн үед мэдрэх чанар нь өсдөг.

Аммиакийн шүү нь шатамхай бодис бөгөөд цэвэр аммиакийн шүүний өөрөө шатах температур нь 3500С байна.

Аммиакийн шүүг хуурай, цэвэр, агааржуулалт сайтай агуулахад хадгалах ба бүтээгдэхүүнийг чийг авахаас хамгаална. Нарны шууд тусгал болон хур тундаснаас хамгаалагдсан задгай талбайд хадгалж болно. Аммиакийн шүүг хадгалах баталгаат хугацаа нь түүнийг үйлдвэрлэснээс хойш 6 сар байна

Технологийн ус: Үйлдвэрлэлд хэрэглэх технологийн ус нь чанарын хувьд ахуйн хэрэглээний усны стандартын шаардлагыг хангасан байна.

Технологийн усны физик-химийн үзүүлэлт

Хүснэгт №2

д/д	Үзүүлэлт	Хэмжээ
1	Устөрөгчийн илтгэгч	pH 6.0-9.0
2	Усны хатуулаг мг-экв/л	<7,0
3	Хуурай үлдэгдэл мг/л	<1000
4	1-р төрлийн гадаргуугийн идэвхит бодис байхгүй	Байхгүй

Хүснэгтэд өгсөн эхний 3 үзүүлэлтийг усны эх үүсвэрээс буюу гүний худагийн уснаас сард 1-ээс доошгүй дээж авч шинжилгээ хийнэ. Харин 4-р үзүүлэлтийг үйлдвэрлэлийн явцад эмульсийн дээж авч хянах ба сард 1-ээс доошгүй удаа үзнэ.

Эмульгатор: ОХУ-ын ТУ 2432-2014 техникийн нөхцлийн дагуу үйлдвэрлэгдсэн «ЭП» маркийн полимер эмульгаторыг үйлдвэрлэлийн зориулалттай эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхэд хэрэглэнэ. Эмульгатор «ЭП» нь «Э» маркийн (продукт синтеза полиизобутиленантарын ангидридыг аминопроизводный-тай урвалд оруулж гаргасан бүтээгдэхүүн) «СМО» эсвэл «ДТМС», «ДТМТ» маркийн эмульгаторын хольцыг үйлдвэрийн тос эсвэл керосинд, эсвэл газрын тосны хандан уусмалд шингэлсэн хольц юм. Эмульгаторыг 5 маркаар үйлдвэрлэдэг: «ЭП-1» ба «ЭП-5» - үйлдвэрийн тосонд уусгасан идэвхэт бодисын уусмал;

«ЭП-2» - керосинд уусгасан идэвхэт бодисын уусмал;

«ЭП-3» ба «ЭП-4» - нефтийн ханданд уусгасан идэвхэт бодисын уусмал.

«ЭП» маркийн эмульгаторыг түүний үйлчлэлд тэсвэртэй материалаар хийсэн саванд хадгална. Торх болон хуванцар саванд хийсэн эмульгаторыг агуулхад эсвэл саравчтай талбайд хадгална. Эмульгаторыг нарны шууд тусгалаас хамгаалах ба +700С хэмээс дээш температурт удаан хугацаагаар хадгалсан тохиолдолд эмульсжүүлэх шинж чанараа алддаг. Хадгалах хугацаа нь үйлдвэрлэснээс хойш 1 жил байна.

Натрийн нитрит: ОХУ-ын ГОСТ 19906-74-ын дагуу үйлдвэрлэсэн натрийн нитрит (NaNO_2) нь хийжүүлэгч нэмэгдэл үйлдвэрлэх үндсэн түүхий эд болно. Натрийн нитритийг полимер уут эсвэл зөөлөвчтэй полиэтилен шуудайнд савлана. Бүтээгдэхүүний бохир жин 50кг-аас хэтрэхгүй байна. Цаасан уутны амыг оёно. Натрийн нитритийг шатамхай бодис материал болон хүнсний бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно. Натрийн нитритийг хүйтэн агуулхад үйлдвэрлэгчийн сав баглаа боодолтой нь хадгална. Бусад төрлийн химийн бодистой хамт хадгалахыг хориглоно.

Бусад химийн бодис: Үйлдвэрлэлийн зориулалттай эмульсийн тэсрэх бодис, түүний үндсэн хольц болох эмульсийг үйлдвэрлэхэд дараах нэр төрлийн химийн бодисуудыг технологийн зааварт заасан орц норм, хэрэглэх зааврын дагуу ашиглана. Эдгээр химийн бодисын хэрэглээ нь харьцангуй бага хэмжээтэй учир импортоор оруулж ирдэг компаниудтай гэрээ хийж дотоодын зах зээлээс хангах боломжтой.

Эрчим хүч

Үйлдвэрээс урд зүгт, 1 км зайд өнгөрөх, 10 кВт-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамнаас салаалан өндөр хүчдэлийн шугам барьж цахилгааны эх үүсвэрээр хангагдахаар тооцов. Шинээр баригдах өндөр хүчдэлийн шугамын зураг,

төсөл, зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагуудаар тусгайлан гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн болно. Үйлдвэрийн дотор цахилгаан эрчим хүчийг трансформаторын дэдстанцаас газар доогуур татсан кабель шугамаар дамжуулан хэрэгцээт газруудад хүргэхээр тооцов.

Усны хэрэглээ

Усан хангамжийн тооцоо Үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээний усан хангамжийг шийдэх зорилгоор үйлдвэрийн хашаанаас зүүн урд зүгт, 40 орчим метрийн зайнд зөвшөөрлийн дагуу гүний худаг гаргасан. Гүний худгаас татах насосоор усыг татаж, 50м³ багтаамжтай усны нөөцийн саванд хуримтлуулна. Татах насос нь усны нөөцийн саванд байрлуулсан мэдрэгчийн тусламжтайгаар автоматаар ажиллах юм.

Усны нөөцийн савыг газрын хөлдөлтийн гүнээс доош байрлуулж, дулаалан ус хөлдөхгүй байх боломжийг бүрдүүлнэ. Усны савнаас цааш нь түгээх насосны тусламжтайгаар хэрэгцээт газруудад усыг хүргэнэ. Усны шугам хоолойг газрын гадрагын хөлдөх гүнээс дор байрлуулна

Усны хоногийн хэрэглээ 30.58м³ байгаа учир 50м³ хэмжээний ус нөөцлөх сав байрлуулахад хоногийн хэрэгцээг хангах хэмжээний нөөц байхаар тооцсон.

Дулааны хэрэглээ

Үйлдвэрийн үйл ажиллагааны дулааны хэрэглээг цахилгаан халаагуур хэрэглэнэ. Цахилгаан халаагуур хэрэглэх учир утаа тортог гарахгүй.

Техник, технологийн сонголт, хүчин чадал

Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт

Үйлдвэрийн хашаан дотор төлөвлөгдсөн авто машины 7.5 метр өргөн, 245 метр урт замыг нийтэд нь цементэлж, түүний дагуу явган хүний зорчих хэсгийг байгуулна.

Харин үйлдвэрийн модулиуд, сэлбэгийн агуулах, авто машины гараж, зогсоолын орчин зэрэг хүнд даацын машины өндөр ачаалал авахгүй хэсгүүдийг хайрган хучилттай хийж, үлдсэн чөлөөт талбайд буюу үйлдвэрийн 1-р бүсэд дүрмийн шаардлагыг харгалзан бут, сөөг тарьж ургуулна.

Эмульсийн үйлдвэрийн харагдах байдал

Зураг 0




Үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд дараах технологийн дотоод талбай, агуулах, зам болон бусад байгууламжуудийг зургийн дагуу барьж байгуулна.

Харуулын байр: Үйлдвэрийн хашаанд гаднаас орох хаалган дээр буюу 1-р бүсэд нэвтрэх хэсэгт харуулын 1-р байр, 2-р бүсэд нэвтрэх хаалган дээр харуулын 2-р байр байрлаж, харуул нь үйлдвэрийн бүсэд нэвтрэх хяналтыг гүйцэтгэнэ.

Оффис, сургалтын байр, удирдлагын модуль: Үйлдвэрийн 1-р бүсэд байрлана. Үйлдвэрийн удирдлага, ИТА нарын ажлын байр, сургалт зааварчилгаа өгөх, ажилчдын түр амрах байр байхаар төлөвлөгдсөн. Энэ байр нь 40 тн-ын чингэлэгт (12200x2550x2800 (40F), байх ба түүнийг 100мм –ийн зузаантай дулаан тусгаарлагч бүхий хөөсөнцөр дулаалгаар доторлож, гэрэлтүүлэг, агааржуулалт болон халаалтын системээр тоноглоно. Оффисийн зориулалтаар тохижуулж, 2 өрөө болгон хуваах ба 1 өрөөг үйлдвэрийн дарга, инженерийн ажлын өрөө, 2 дахь өрөөг сургалт хийх, зааварчилгаа өгөх, хурал цуглаан хийх зориулалтаар тохижуулж ашиглана. Ажилчдын түр амрах байр нь тохижуулсан 40тн-ын чингэлэг байх ба түүнийг 2 өрөө болгон тусгаарлаж, 1 талд нь эрэгтэй ажилчид хувцас солих, түр амрах, нөгөө талд нь эмэгтэй ажилчид хувцас солих зориулалтаар хувцасны шкаф, ширээ, сандал бусад шаардлагатай зүйлсээр тоноглож ашиглана.

Зураг 0.2 Оффис, сургалтын байр



Эрүүл ахуйн байр, септик систем: Эрүүл ахуйн байр нь үйлвэрийн 1-р бүсэд байрлана, дулаан тусгаарлагч бүхий хөөсөнцөр дулаалгаар доторлож, агааржуулалт болон халаалтын системээр тоногдсон 20тн-ын чингэлэгийг ариун цэврийн өрөө, шүршүүр, бие засах газрын зориулалтаар тохижуулж ашиглана. Эрүүл ахуйн байрнаас гарсан бохир усыг хуримтлуулах зориулалттай септик системийг зураг төслийн дагуу хийж ашиглана.

Цэнэглэгч машины гараж: Цэнэглэгч машины гараж нь үйлдвэрийн 1-р бүсэд байрлана, 45х20м талбайд технологийн 4 машины гаражийг барихаар төлөвлөсөн. Уг гаражийг төмөр каркастай, сэндвичэн материалаар зургийн дагуу барина. Гаражийн хойд талын 1 тасалгаанд засварын байр, технологийн машиныг уураар цэвэрлэх төхөөрөмжтэй байна. Гаражийг галын дохиолол, хяналтын камер, агааржуулалт болон халаалтын системээр бүрэн тоноглоно. Аюулгүй ажиллагааны анхааруулах болон хориглох тэмдэг, тэмдэглэгээ, санамж, галын аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулна.

Цэнэглэгч машины зогсоол: Үйлдвэрийн 1-р бүсэд байрлана, 35х12м-ийн хэмжээтэй 420м² талбайд технологийн машиныг түр хугацаагаар зогсох, ажилд гарахын өмнө болон ажлын дараа үзлэг хийх, цэвэрлэгээ үйлчилгээ хийхэд зориулагдсан. Талбай нь хайрган хучилттай талбай байна.

Сэлбэгийн агуулах, засварын газар: Үйлдвэрийн 1-р бүсэд байрлана, 40тн чингэлэгт үйлдвэрийн болон цэнэглэгч машины сэлбэг, засварын багаж, хэрэгслийг хадгалах зориулалттай. 20тн чингэлэгт засварын төхөөрөмж, багаж хэрэгсэл суурилуулан засварын байр болгон ашиглана.

Үйлдвэрийн үндсэн модулиуд: Үйлдвэрийн талбайн 2-р бүсийн төвд 31х26 метрийн хэмжээтэй хайргажуулсан талбайд эмульс үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмж бүхий модулиуд байрлана. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн газардуулгыг хийж, модулиудын орчныг аянга хамгаалагчуудаар хамгаалсан байна.

Аммиакийн шүүний агуулах: Үйлдвэрийн 2-р бүсэд 15х50м-ийн хэмжээтэй 750 м2 талбайд аммиакийн шүүний агуулгыг барихаар төлөвлөсөн. Агуулхын хийц нь төмөр каркас, сэндвичэн хана, сэндвичэн дээвэртэй, бетонон шалтай байна. Агуулхад зөөлөн чингэлэгт 1000 кг-аар савласан сэвсгэр болон гялгар шүүг хадгална. Агуулхын нийт багтаамж 500тн, үүнээс 160 тн сэвсгэр, 340 тн гялгар шүү хадгалахад зориулагдсан байна. Аммиакийн шүүний агуулах нь байгалийн агааржуулалттай байх ба гэрэлтүүлэг, хяналтын камер, утаа мэдрэгч, дохиоллын системээр тоноглоно. Аммиакийн шүүг тээврийн хэрэгслээс буулгах, агуулхад хураах, бункер ачаалах, цэнэглэгч машинд ачих бүх үйлдлийг сэрээт ачигчаар гүйцэтгэнэ.

Эмульгатор болон үйлдвэрийн тос хадгалах талбай: Үйлдвэрийн 2-р бүсэд 15х19 м-ийн хэмжээтэй бетондсон талбай байна. Үйлдвэрлэлийн хүчин чадлын тооцооллоор 205 литрээр төмөр торхонд савласан, хамгийн ихдээ 12 тн эмульгатор, 44 тн үйлдвэрийн тос хадгална.

Химийн бодисын агуулах: Үйлдвэрийн 2-р бүсэд 40 тн-ын 4 ш чингэлэгийг химийн бодис хадгалах зориулалтаар тохижуулж байрлуулна. Агуулах нь агааржуулалттай байна. Химийн бодисыг тус бүрийн хадгалах зааврын дагуу зориулалтын тавиур дээр байрлуулж сав баглаа боодлын битүүмжлэлийг алдагдуулахгүйгээр хадгална.

Сав баглаа боодлын талбай: Үйлдвэрийн 2-р бүсэд 15х19м-ийн хэмжээтэй хайрган хучилттай талбай байна. Аммиакийн шүүний шуудай, зөөлөн чингэлэг, үйлдвэрийн тос болон эмульгаторын төмөр торх, химийн бодисын сав баглаа боодлыг цуглуулж, устгалд явуулах хүртэл хугацаанд түр хадгалах зориулалттай.

Амрах байр: Эмульсийн үйлдвэрийн төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд үйлдвэрийн ажигчид нь “Өсөх зоос” компанийн ажигчдын байранд байрлана. Пауэр бласт, Өсөх зоос ХХК нарын хооронд хийсэн гэрээний дагуу.

Байр, хоол, угаалга, цэвэрлэгээний асуудал нь гэрээгээр зохицуулагдах бөгөөд ахуйн хог хаягдал нь мөн гэрээт компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдан зохицуулагдана.

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь орчны эрс тэс уур амьсгалтай нөхцөлд найдвартай ажиллахаар бүтээгдэж, ОХУ-ын Сибирь, Якутын хүйтэн болон Африкийн халуун цаг уурын нөхцөлд ажиллаж баталгаажсан тоног төхөөрөмжүүд бөгөөд, үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүн нь ч дээрх нөхцөлд чанар, шинжээ алдахгүй нь тогтоогдсон юм.

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь үндсэн хоёр дамжлага хэсгээс бүрдэнэ.

Эмульсийн тэсрэх бодисын үл тэсрэх үндсэн хольц болох эмульс үйлдвэрлэх суурин үйлдвэр

Эмульсийн тэсрэх бодисын түүхий эдүүдийг тээвэрлэх, уурхайн тэсэлгээний цооногт тэсрэх бодис болгон цэнэглэх зориулалттай, тусгайлан тоноглогдсон цэнэглэгч машинууд

Эмульс буюу үл тэсрэх хольцын үйлдвэрт эмульсийг технологийн зааврын дагуу үйлдвэрлэнэ. Эмульс болон эмульсийн тэсрэх бодисын найрлага нь өвөрмөц, энгийн бүрэлдхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

Эмульсийн найрлагад нь дизелийн түлш ороогүй тул үйлдвэрлэлийн процесс нь галын аюулын зэрэглэлээр аюул багатай ангилалд хамаарна.

Талбайн газар ашиглалт

Тэсрэх материалын үйлдвэр, агуулахын зориулалтаар ашиглаж буй нийт 30,000м² газар нь ГНС-н ангиллын Хот, тосгон бусад суурины газрын дэд ангилал болох үйлдвэрийн газрын ангилалд хамаарна.

Эзэмшлийн 20000м², 10000м² талбайн хувьд өмнө ямар нэгэн ашиглалт явуулаагүй сул чөлөөтэй талбай байсан ба одоогийн байдлаар агуулахын зориулалтаар 20000 м² талбайн 11124.2м² талбайд ашиглалт явуулж байна. Тус ашиглалт явуулж буй талбайн 4890.2м² талбай нь эзэмшлийн талбайн гадна буюу зөвшөөрөлгүй талбайд хамаарагдаж байна.

Агуулахын зориулалтаар ашиглаж буй талбайд гал түймэр болон үерийн суваг, автомашины зогсоол, харуулын байр, бие засах газар, бүтээгдэхүүн хадгалах контейнер, түүхий эд хадгалах талбай, галын сарай зэрэг байгууламжууд байрлах ба нийт 2098м² талбайг буюу 8.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 0.1 Талбайн газар ашиглалт

№	Ангилал	Талбай м ²
1	Агуулах /Ашиглалт явуулж буй талбай/	20,000

1.1	Бүтээгдэхүүн хадгалах контейнэр /Тэсрэх бодисын агуулах/	229.3
1.2	Түүхий эдийн талбай	388.4
1.3	Бие засах газар	7.3
1.4	Харуулын байр	16.3
1.5	Зосгоол	549.4
1.6	Галын сарай	55.0
1.7	Шороон далан	475.4
1.8	Гал түймрийн болон үерийн хамгаалалтын суваг	377.1
1.9	Ашиглалт явуулж буй талбай	9,026.0
1.10	Сул чөлөөтэй талбай /хашааны гадна талд байгаа, одоогийн байдлаар ашиглалт явуулаагүй/	13,766.1
2	Сул чөлөөтэй талбай /Үйлдвэр баригдах талбай/	10,000
Нийт		30,000

Цаашид тэсрэх материалын үйлдвэрийн үйл ажиллагаанд зориулан ММТЛ-250 технологийн шугам, аммиакийн шүүний бүнкер, эмульс үйлдвэрлэх модуль, хийжүүлэгч нэмэгдлийн модуль, эмульгатор ба масло халаах модуль, эмульс шахах модуль, эмульсийн танк, лаборатори, оффис сургалтын байр, ариун цэврийн байгууламж, засварын газар, харуулын байр, дэд станц, нөөцийн генератор, химийн бодисын агуулах, сав баглаа боодол хадгалах талбай, усны сав /галын усны нөөц/, галын гидрант, гүний худаг, цэнэглэгч машины зогсоол, гараж, септик /бохирын шугам/, аммиакийн шүүний агуулах, хогийн цэг, сэлбэгийн агуулах, галын сарай, тэсрэх материалын агуулах зэрэг барилга байгууламжийг 10000м² талбайд барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгасан болно.

Байгаль орчинд учруулах нөлөөллийн үнэлгээ

Аргачлал

Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрийн төслөөс үүсч болзошгүй нөлөөллийн үнэлгээг БОАЖ-ын сайдын 2010 оны 01 сарын 12-ны өдрийн 3104 дугаарт бүртгэсэн А/02 тушаалаар баталсан аргачлалын дагуу болон нөлөөллийн оноот үнэлгээний аргыг тус тус ашиглан гүйцэтгэв.

Оноот үнэлгээний арга нь нөлөөллийн үр дагавар, нөлөөлөлд өртөгдсөн талбай болон байгаль орчны чадамжид судлаачийн үзэмжээр оноо өгч, энэ нь байгаль орчны нөлөөллийн судалгаанд хэрэглэх мэдээллийн тодорхой түвшинг тогтооход ашиглагдана.

Шалгуур оноонд:

Үр дагаврыг байгаль орчны сүйрлээр (А1), байгалийн нөөц ба хүрэлэн буй орчны чанарт үзүүлэх нөлөөгөөр (А2) тохиолдох магадлалаар (А3);

Үр нөлөөний хамрах хүрээг орон зайгаар (В1), үргэлжлэх хугацаагаар (В2);

Сөрөг нөлөөллийг даах байгалийн чадавхийг, нөхөн сэргээгдэх байдлаар (С1) тус тус үнэлнэ.

Нөлөөлөл нь (I) эерэг (+), сөрөг (-) болон тодорхой бус (0, нөлөөгүй) байна.

Нөлөөллийн шалгуур оноог Хүснэгт 5.2-д үзүүлэв. Нөлөөллийн хуримтлалын зэргийг $I * (A1 + A2 + A3 + B1 + B2 + C1)$ томъёогоор тооцоолох ба нөлөөллийн зэргийн шалгуурыг Хүснэгт 5.1-д үзүүлэв.

Хүснэгт 0.2 Нөлөөллийн үнэлгээний цар хүрээ

No.	Тэмдэг	Үзүүлэлт	Нөлөөллийн оноо		
1	I	Нөлөөлөл	Эерэг (1)	Сөрөг (-1)	Нөлөөгүй (0)
2	A1	Байгаль орчны	Их (3)	Дунд (2)	Хязгаарлагдмал

		сүйрэл			(1)
3	A2	Байгалийн нөөц, орчны чанарт учруулах нөлөө	Их (3)	Дунд (2)	Бага (1)
4	A3	Болох магадлал	Болох магадлал их (3)	Болох магадлалтай (2)	Магадлал бага (1)
5	B1	Нөлөөлөлд хамаарах хүрээ	Бүсийн (3)	Орон нутгийн (2)	Тодорхой цэгт (1)
6	B2	Үргэлжлэх хугацаа	Урт хугацаа (3)	Дунд хугацаа (2)	Богино хугацаа (1)
7	C1	Нөхөн сэргээгдэх байдал	Сэргээгдэхгүй (3)	Хэсэгчилэн сэргээгдэх (2)	Бүрэн сэргээгдэх (1)

Хүснэгт 0.3 Нөлөөллийн зэргийн түвшний шалгуур

Сөрөг нөлөөлөл		Эерэг нөлөөлөл	
Нөлөөллийн түвшин	Нийт оноо	Нөлөөллийн зэрэг	Нийт оноо
Их	≤ -15	Их	$+15 \leq$
Дунд	$(-15,-9)$	Дунд	$(+9,+15)$
Бага ба нөлөөгүй	$-9 <$	Бага	$\leq +9$

Байгаль орчны нөлөөлийн үнэлгээний нэгтгэл

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн байгууламж нь байгальд хортой нөлөө шууд үзүүлдэггүй, гэнэтийн осол болон байгалийн гамшиг мөн ХАБЭА ноцтой зөрчил гарсан үед байгаль орчин болон хүнд ноцтой хохирол үүсгэнэ. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлж үргэлжлэн явагдах явцад зохих хатуу болон шингэн хог хаягдал гарах боловч байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь бага байгаа тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

Төслөөс байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын ус, газрын доорхи ус, хөрс, ургамал, амьтанд үзүүлэх

байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлсон. Үнэлгээний нэгдсэн үр дүнг Хүснэгт 5.3-д үзүүлэв.

Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн

Хүснэгт

Нөлөөлөлд өртөгч	Байгаль орчны сөрөг нөлөөллийн түвшин		
	Их	Дунд	Бага ба нөлөөгүй
Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл		Дунд	
Уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл			Бага ба нөлөөгүй
Агаарын чанарт үзүүлэх нөлөө			Бага ба нөлөөгүй
Гадаргын усанд үзүүлэх нөлөө			Бага ба нөлөөгүй
Газрын доорх усанд үзүүлэх нөлөө			Бага ба нөлөөгүй
Хөрсөнд үзүүлэх нөлөө		Дунд	
Ургамалд үзүүлэх нөлөө		Дунд	
Амьтны аймагт үзүүлэх нөлөө			Бага ба нөлөөгүй

Нэгдсэн дүнгээс үзвэл төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага боловч газрын гадарга, хөрс, ургамал зэрэгт дунд зэргийн сөрөг нөлөөтэй учраас бууруулах арга хэмжээ авч ажиллана. Энэ нь төслийн ажил эхлэх үед тодорхой талбайд барилга байгууламж барих, машин техник явах үед хөрсний элэгдэл, эвдрэл мөн ургамлын талхагдал үүсэх зэрэг нөлөөлөл үүсэх магадлалтай тул урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зорилтыг тавиж ажиллана.

“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгахад чиглэсэн тулгуур хэрэглэгдэхүүн бөгөөд байгаль хамгаалах ажлыг жил бүр нарийвчлан тогтоож хэрэгжүүлэх,

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож жил бүр байгууллагынхаа төсөвт тусгаж байх, тус төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж ажиллах,

Төслийн үйл ажиллагаа, техник технологийг өөрчилж, шинэчлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг эрх бүхий аж ахуйн нэгжээр хийлгүүлэх,

Нийт ажиллагсдад байгаль хамгаалах талаар хууль тогтоомжийг танилцуулан энэ талын мэдлэг эзэмшүүлэх, амьдрал дээр хэрэгжүүлэх талаар удирдлагын зүгээс байнга зөвлөмж өгч ажиллах.

БОННУ-ний заалтуудыг хэрэгжүүлэнэ.

4. Сөрөг нөлөөллийг бууруулах,

Арга хэмжээний төлөвлөгөө

Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулахаас сэргийлж ажиллана.

Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэхийг авч үзнэ.

Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулахаас сэргийлж ажиллана.

Төслийн талбайн урд хэсэгт буюу цугларах цэгийн хажууд болон хашааны хойд хэсэгт тухайн нөхцөл дэх агаараас хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос (TSP) гэсэн гурван үзүүлэлтээр дээж авч Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторит шинжлүүлж, агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулж үнэлгээ өгч ажиллана.

АГААРЫН ЧАНАР

№	Авах арга хэмжээ	Хаана	Хэрэгжүүлэх хэлбэр
3.1.1	Орчны тоосжилтыг бууруулах зорилготой зам дагуух усалгаа, автомашины хурдны хяналт тавих	Үйлдвэрээс Уурхайн технологийн зам, үйлдвэр доторх зам талбай.	Үйлвэрийн аюулгүй ажиллагааг хангах, орчны тоосжилтыг багасгах зорилгоор технологийн зам, талбайд тоосжилт ихтэй үед тогтмол усалгаа хийгдэж хурдны хязгаарт хяналт тавина.

3.1.2	Ажилчдын оффиссын орчинд амрах бүрдүүлэх, тоосжилтоос хамгаалах	ТМ-19 үйлдвэрийн оффиссын орчинд	Үйлдвэр дотор амрах талбай байгуулах, оффиссын дотор талыг зүлэгжүүлэх
-------	---	----------------------------------	--

4.2 Хөрсөнд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үнэлгээнд авч үзэх асуудал

Хөрсөн бүрхэвч эвдрэх эсэх

Хөрс бохирдуулах эсэх

Хөрс доройтох, цөлжих эсэх

Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн ажиллана.

Үйлдвэрийн бүсрүү орж гарах нэг зам засаж сайжруулан өөр зам гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллана.

ХӨРС

Хүснэгт№

№	Арга хэмжээ	Хаана	Хэрэгжүүлэх хэлбэр
3.2.1	Маршрутын бус зам үүсгэхгүй байх	Газрын эдэлбэрийн хэмжээнд	Тусгай зөвшөөрлийн хил доторх замыг тэмдэгжүүлэх, холбогдох дүрмийг талуудад мэдээлэх
3.2.2	Ахуйн хог хаягдал болон нефть бүтээгдэхүүнээр хөрс бохирдохоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих	ТМ-19 үйлдвэрийн засварын хэсэгт хаягдал тос Түр цэг цуглуулах байгуулна.	Үйл ажиллагаандаа ажлын байрны эмх цэгцгийг сахих, асгаралтын иж бүрдлийг ажлын байр, талбайд байршуулна. Асгаралт үүссэн тохиолдолд арилгах арга хэмжээ даруй авна. Бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд байршуулж, саармагжуулна

3.2.3	Агуулах, түүхий эдийн талбайг сайжруулах	Түүхий эдийн талбай болон бүтээгдэхүүний агуулах:	Агуулах, түүхий эдийн талбай, харуулын байр, цугларах цэг орчимыг хатуу хучилттай болгоно.
3.2.4	Үйлдвэрийн гадна тайлбайг хамгаалах	Хамгаалалтын шуудуу	Мөн эзэмшлийн талбайн гадна талаар үерийн уснаас хамгаалах үүднээс 1.0 м өргөнтэй, 0.5 м гүнтэй хашааны 4 талыг тойруулан хамгаалалтын шуудуу татна. Хөрсийг нь шуудууны амсар дээр нь овоолж нуруулдсанаар /шорооны өндөр 1м, 40 ⁰ градусын налуу/ нэг талаасаа гал, үерийн аюулаас хамгаалах арга хэмжээ авч ажиллана.

4.3 Газрын доорхи усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үнэлгээнд авч үзэх асуудал

Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэхээс сэргийлэх

Төслийн талбайд хэрэглэж байгаа уснаас дээж авч Инженер Геодези ХХК-ны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, шинжилгээний үр дүнгийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

УСАН ОРЧИН

№	Арга хэмжээ	Хаана	Хэрэгжүүлэх хэлбэр
3.3.1	Малчны худаг сэргээн засах	1 худгийг сэргээн засварлах	Орон нутгийн иргэдийн санал, хяналт дор зохион байгуулж тайланг Засаг даргын зөвлөлд танилцуулна.

3.3.2	Булгийн эхийг хашиж хамгаалах	Өмнө хийж өгсөн булгийн эхийг чанар муудсан хашааг засаж орон нутагт хүлээлгэж өгнө.	Орон нутгийн иргэдийн санал, хяналт дор зохион байгуулж тайланг Засагдаргын зөвлөлд танилцуулна.
-------	-------------------------------	--	--

Үйлдвэрт хэрэглэгдэх усны хэрэгцээ

Унд ахуйн хэрэглээний ус: Үйлдвэрт нийт 30 хүн ажиллана.

Хүн амын унд, ахуйн хэрэглээний түр норм

Ус хэрэглээний нэр, төрөл	Ус хэрэглээний хоногийн дундаж норм, л/хон/хүн
Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц	150

Хүн амын унд, ахуйн хэрэгцээ

Жил	Хүн амын унд, ахуйн хэрэгцээ м ³				
	Норм (л/хон)	Ажиллах хүний тоо	м ³ /хоног	Хоног	Усны хэмжээ м ³
1	150	30	4.5	365	1642.5
2	150	30	4.5	365	1642.5
3	150	30	4.5	365	1642.5
4	150	30	4.5	365	1642.5
5	150	30	4.5	365	1642.5
Нийт					8212.5

Ногоон байгууламж, замын усалгаа: Ногоон байгууламжийн усалгааг 6 сар буюу 180 хоногт 1 өдөр өнжөөд нийт 90 хоног усалгаа хийнэ. Харин замын усалгааг 6 сар буюу 180 хоногт усалгаа хийнэ гэж үзээд тооцоо хийлээ. Иймд ногоон байгууламж болон замын усалгааг Байгаль орчны Сайдын 2015 оны 301 дүгээр тушаалын дагуу тооцоо хийлээ.

Зүлэг талбайн усалгааны түр норм

Усалгааны төрөл	Хэмжих нэгж	Усалгааны норм литр
Цэцэрлэг зүлэг ногоог услах	м ²	4.0
Гудамж зам талбай	м ²	2.0

Ногоон байгууламжийн талбай $300\text{м}^2 \times 4.0\text{л} = 1200\text{л}$ буюу 1.2м^3 ус, жилд 180м^3 ус.

Замын талбай 9000м^2 . $9000\text{м}^2 \times 2\text{л} = 1800\text{л}$ буюу 18м^3 ус, жилд 3240м^3 нийт 16200м^3 ус усалгаа хийнэ.

Нийт ногоон байгууламж усалгаанд $19.2\text{м}^3/\text{х}$ ус буюу $0.22\text{л}/\text{с}$ ус хэрэглэнэ.

Технологийн усны хэрэглээ:

Хүснэгт 0.4 Эмульсийн тэсрэх бодисын найрлага, хэмжээ

№	Түүхий эд, бодисын нэрс	1 Сарын хэрэглээ, тн	1 жилийн хэрэглээ, тн
1	Аммиакийн шүү /гялгар/	667.53	8,010.34
2	Ус	103.39	1,240.73
3	Эмульгатор	8.50	102.05
4	Үйлдвэрийн тос	34.02	408.20
5	Натрийн нитрит	1.73	20.71
6	Сульфамины хүчил	0.26	3.15
7	Тиомочевин	0.26	3.15
8	Уротропин	0.26	3.15
9	Этиленгликоль	4.72	56.70
10	Тиоцианит натри	0.08	0.99

11	Цууны хүчил	0.90	10.85
----	-------------	------	-------

“Пауэрблест” ХХК-ны технологиор 1тонн эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхэд 0.17м³, цэнэглэгч машины цэвэрлэгээнд 2.5м³ ус тус тус орно. Цэнэглэгч машины бүрэн цэвэрлэгээг 14 хоног 1 удаа хийнэ.

Жилийн 250 хоногт нь тэсрэх бодисоо үйлдвэрлэдэг, үлдсэн хоногт нь засвар үйлчилгээ болон амралтын хоног орж байна.

Жилд дундажаар 9860тн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай. Иймд хоногт 39.44тн тэсрэх бодис үйлдвэрлэхэд 6.7м³/х ус, жилд 1676.2м³ ус хэрэглэхээр байна. Харин цэнэглэгч машины бүрэн цэвэрлэгээнд 14 хоногт 2.5м³ ус, жилд 65м³ ус хэрэглэнэ. Тэсрэх бодис болон цэнэглэгч машины цэвэрлэгээнд нийтдээ 6.88м³/хон буюу 0.079л/с ус хэрэглэнэ. Үйлдвэрийн жилийн төлөвлөгөө

Жилд хэрэглэгдэх усалгааны усны хэрэглээ

Хүснэгт 0.5

Зориулалт	Талбай м ²	Усалгааны норм л/м ²	Усалгаа хийх хоног	м ³ /хоног	м ³ /жил	Таван жилд
Ногоон байгууламж усалгаа	300	4	180	1.2	180	900
Зам	9000	2	180	18	3240	16200
Нийт						25200

Зарцуулах усны тооцоо

Хүснэгт 0.6

Зориулалт	м ³ /хоног	м ³ /жил
Ундны болон ажиллагсдын ахуйн хэрэгцээний ус	4.5	1,642.50
Усалгаа	19.2	3,420.00
Үйлдвэрийн ус	6.88	1,720.00

Нийт	30.58	6,782.50
------	-------	----------

2023 онд хэрэглэх усны хэрэглээг хянахдаа худаг дээр суурьлуулсан усны тоолуурын заалтаар хянаж жилийн эцэст усны тайланг орон нутагтаа тайлагнана.

5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

ТМ-19 үйлдвэр дээр хөрс хуулах шимт хөрсийг хөндөх ажил явагдахгүй тул шороон зам талбайн хаалт хамгаалах ажлуудыг хийнэ.

Тарьсан модны ургалтыг хангах

Үйлдвэрийн байр болон сумын эргэн тойронд тарьж ургуулж байгаа нийт модны ургалтыг хангах зорилгоор арчилгаа, усалгааг дулааны улирлын турш тогтмол хийх үүрэгтэй. Тус зорилгын хүрээнд улирлын чанартай туслах ажилтнуудыг гэрээгээр авч ажиллуулах болон усны эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах, шаардлагатай багаж төхөөрөмж усалгааны систем болон бусад бэлтгэлийг хангаж ажиллана.

Модлог ургамлын нөөц бүрдүүлэх, ногоон байгууламж

Туршилт ЫН Чиглэл	Тодорхойлолт	Байршил	Хэмжээ, талбай
Мод хөтөлбөр	Тербум мод тарих хөтөлбөрийн хүрээнд	Гурван тэс сум	1200 ширхэг модлог ургамал тариалах, үржүүлэх

Сумын мод тарих талбайд тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Ногоон байгууламжийн өргөтгөлийн төлөвлөгөө

Ногоон байгууламж	Өвслөг	Модлог	Тарих модны тоо
Сумын мод тарих цэгт	Олон наст	Хайлаас, шар хуайс, улиас /тарилт/	1200

Зүлэгжүүлэх

Нэр	Тоо хэмжээ	Нэр төрөл	Тайлбар
Зүлэгжүүлэх	25м ²	Ботула	

ТМ-19 үйлдвэрийн оффиссын ойр орчны талбайд зүлэгжүүлэлт хийнэ.

6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“ПауэрБласт” ХХК-ийн хувьд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлснээр зэрлэг амьтдын амьдрах орчин б дээшилнэ гэж үзэж байна.

Туруутан амьтны амьдрах орчин, идэш тэжээлийн нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн биотехникийн арга хэмжээний судалгаа

Цаг агаар хүндэрсэн үед туруутан амьтны зээрийн өвөл, хаврын бэлчээрт өвс, тэжээл бэлтгэн тавьж өгөх зэргээр биотехникийн арга хэмжээг тус амьтанд чиглүүлэн хэрэгжүүлэх судалгаа хийх.

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд зарцуулах ажлын төсөв

#	Арга хэмжээ	Цар хүрээ	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв (сая төгрөг)
1	Зэрлэг амьтадын биотехникийн арга хэмжээ	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Цаг агаар хүндэрсэн үед туруутан амьтны зээрийн өвөл, хаврын бэлчээрт өвс, тэжээл бэлтгэн тавьжөгах ажил	3.00
2	Усан хангамжийг сайжруулах	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Уст цэгийн судалгаа хийж булаг шандыг хамгаалах	1.00

7. Түүх соёлын өвд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө

Үйлдвэрийн талбайд түүх соёлын дурсгалт олдвор байхгүй. Гэхдээ төсөл хэрэгжүүлэх үед ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл мэргэжлийн байгууллагад хандан авран хамгаалах арга хэмжээг авч ажиллана.

Орон нутгын иргэдэд тайлант хурлаар тухайн жил авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг тайлагнана.

Өөрийн компанийн ажилчиддаа тухайн орон нутгын түүх соёлын дурсгалт газруудын талаар хайрлан хамгаалах талаар сургалт орно.

8. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Химийн бодисыг тээвэрлэх үед байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайд, онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаал баталсан “Хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг баримтлан ажиллана.

Химийн хорт болон аюултай бодисыг анхааруулах аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан, техникийн болон аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ.

Химийн хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэнэ.

Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих ба шингэн бодисын хувьд савны амыг дээш харуулан босоогоор байрлуулна.

Химийн хорт болон аюултай бодисын ангиллын “а” зэрэглэлийн бодисыг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба энэ үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврыг хатуу сахина.

Химийн хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цаг-аас хэтрэхгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байвал зохино.

Химийн хорт болон аюултай бодисын хайрцаг, сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгслэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглээгүй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.

Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгсэлийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химийн бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулна.

Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслээс хоёр тийш 100 м зайд “орохыг хориглоно” гэсэн тэмдгийг байрлуулна.

Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай элс, хувин гэх мэт/, хор саармагжуулах бодис, уусмалаар тээврийн хэрэгсэл бүр хангагдсан байна.

Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх маршрутыг аль болох хөдөлгөөн багатай, тэгш сайн байхаар сонгож, хэзээ, хаанаас тээвэрлэх талаархи мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ба аюулгүй байдлыг хангуулсан байна.

Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хот, суурин газрын дотор болон ойролцоо удаан хугацаагаар зогсоохыг хориглоно.

Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслэлийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.

Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх бусад шаардлагыг аюултай ачаа тээвэрлэх техникийн нөхцөл, стандартад тусгана.

Ашиглах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг өөрийн тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.

Химийн хорт болон аюултай бодисыг хүн, мал, амьтан болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

Химийн хорт болон аюултай бодисыг цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ

Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цувааны ахлагч) цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрмийг баримтлан, химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана.

Цувааны ахлагч цувааны эхний машинд явах бөгөөд тээвэрлэж буй ачаа, цаг агаарын нөхцөл, цуваанд яваа техник хэрэгслийн байдал зэргийг харгалзан бүх төрлийн замд хурд ба машин хоорондын зайг тохируулж явах үүрэгтэй;

Цувааны эхний болон сүүлчийн тээврийн хэрэгсэл “цуваа” гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг тээврийн хэрэгсэл бүрийн урд болон ар талд харагдахуйцаар жигд байрлуулна;

Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх цувааны эхэнд хамгаалалтын машин, төгсгөлд нөөц тээврийн хэрэгсэл явах ба өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.

Химийн хорт болон аюултай бодис хадгалах үеийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ

Химийн бодисыг тээвэрлэх үед Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг баримтлах ба энэ журмын дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана.

Химийн хорт болон аюултай химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална;

Химийн хорт болон аюултай бодисын агуулахыг хүн ам оршин суугаа газраас 300-аас доошгүй метрийн зайд, үер усанд автахааргүй байрлалд байрлуулах ба агуулах нь галд тэсвэртэй материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна.

Химийн бодисын агуулах нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн тохиолдолд тэдгээрийг хадгалах бодисын хэмжээнээс хамаарч гал тархах боломжийг хязгаарласан зайд байрлуулах ба хэсэг бүр нь дотроо хамт хадгалж болох бүлэг бодисыг тусад нь хадгалах зориулалт бүхий өөр хоорондоо битүү тусгаарлагдсан өрөө тасалгаатай байна;

Химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторх нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгална;

Химийн бодисыг хүний нүдний түвшингээс дээш түвшинд байрлах тавиур дээр тавихыг хориглох бөгөөд химийн бодисын тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байна;

Химийн бодисыг шалан дээр хурааж хадгалах тохиолдолд хүн явах зам гарган байрлуулах ба гарцыг хааж болохгүй;

Шингэн химийн бодисыг хагардаггүй эсвэл бат бөх хагардаггүй давхар савалгаатай саванд хадгалах ба хадгалах агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байвал зохино;

Дэгдэмхий эсвэл хурц үнэртэй химийн бодисыг шаардлага хангахуйц агааржуулалтын системээр тоноглогдсон агуулахад хадгална;

Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгална.

Химийн бодисын агуулахад асгарч гоожсон эсвэл эвдэрхий сав, баглаа боодолтой химийн бодисыг хадгалахыг хориглоно;

Химийн бодисын агуулахад ил гал гаргах, шүдэнз зурахыг хориглоно;

Химийн хорт болон аюултай бодисыг юүлэх, савнаас нь хэсэгчлэн авахдаа зөвхөн тусгай тоногосон /салхивч, агааржуулалтын систем, шингэний шахуурга гэх мэт/ агуулахад гүйцэтгэнэ;

Химийн бодисын агуулах нь ажиллагсдын гар угаах, усанд орох, хувцас солих нөхцлөөр хангагдсан байна;

Агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулна. /Жишээлбэл: галын аюултай, хортой гэх мэтийг анхааруулсан тэмдэг, “Шатамхай шингэн”, “Хортой”, “Идэмхий” гэх мэт дохио үг/;

Химийн бодисын агуулах нь гаднын хүн үл нэвтрэх хаалт, цоожтой байх ба онцгой хортой, аюултай бодис хадгалах агуулах нь зөвхөн хариуцагч этгээдийн хувийн тэмдэг бүхий лацаар битүүмжлэгдсэн байна;

Агуулах нь хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна;

Химийн бодисын агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно.

Заасан аргачлалын дагуу байгаль орчин, эрүүл ахуй болон гамшгаас урьдчилан сэргийлэх улсын байцаагч нарыг байлцуулж зориулалтын цэгт устгана.

Химийн бүтээгдэхүүн, хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

Аюултай ачаа тээврийн жолооч нарт сургалтыг тогтмол явуулах.

Эрсдэлийн үнэлгээнд тухайн химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдэлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэн устгана.

Химийн бодис ашиглах үйл ажиллагааны шат дамжлагуудад гарч болзошгүй аюул осол, эрсдэлд өртөгчид, химийн бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчныг бохирдуулах, дамжиж болзошгүй арга замууд зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэн эрсдэлийн урьдчилсан таамаг, дүр зургийг гаргаж, доорх хүснэгтэнд харуулав.

Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө				
Тээвэрлэх үеийн тохиолдож болзошгүй эрсдэл	Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Төсөв	Хариуцах эзэн	Тайлбар
Химийн бодис тээвэрлэх үед сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах улмаар хөрс, агаар гэх байгаль орчны бүрэлдхүүн хэсгүүдэд нөлөөлөх	Тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөх болзошгүй аюул, осол аваар гарахаас сэргийлэх.	-	Үйлдвэрийн дарга, Хөдөлмөр хамгааллын ажилтан, агуулахын нярав	MNS4584: 2007 “Агаарын тухай хууль”
Бодисын савны найдваргүй байдлаас бодис асгарах, орчинд алдагдах, гал гарах, тэсэрч дэлбэрэх	Бүх төрлийн химийн бодисын хадгалалтын үеийн аюулгүй байдлыг хангаж ялангуяа шатах аюултай химийн бодисыг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусхааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах.	-	Үйлдвэрийн удирдлага, Хөдөлмөр хамгааллын ажилтан, агуулахын нярав	“Байгаль орчныг хамгаалах тухай хууль” “химийн хорт болон аюултай бодисын тухай хууль” Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2-р бүлгийн 13-р зүйл “Химийн хорт болон
Хүний эрүүл мэнд байгаль орчинд хохирол учруулах	Химийн бодисыг хадгалах, үеийн савны бүрэн бүтэн байдлыг хянах.	-	Хөдөлмөр хамгааллын ажилтан, агуулахын нярав	

Үйлдвэрийн ажилчин	Ажилчдын хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх	-	Хөдөлмөр хамгааллын ажилтан, агуулахын нярав	аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлага”-н 1,2
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	Гэнэтийн осол (гал түймэр, тэсрэлт, хортой бодис алдагдах гэх мэт) гарсан тохиолдолд авах арга хэмжээний шуурхай ажлын удирдамж төлөвлөгөөтэй байх	300.000 төг	Хөдөлмөр хамгааллын ажилтан	
Хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд хохирол учруулах	Эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх бодис материал (хүчил шүлтийг саармагжуулах уусмал, цэвэр ус, эмийн сан гэх мэт)-ыг бэлэн байлгаж ажиллагсдыг анхан шатны тусламжийг бие биедээ үзүүлэх арга зүйн мэдлэгтэй болгох	300.000 төг	Хөдөлмөр хамгааллын ажилтан	
Хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд хохирол учруулах	Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад саармагжуулах бүтээгдэхүүнийг олгож эрүүл мэндийг хамгаалана.	2.000.000 төг	Хөдөлмөр хамгааллын ажилтан	

Хадгалах үед тохиолдож болох эрсдэл	Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	Төсөв	Хариуцах эзэн
Химийн бодис хадгалах үеийн болгоомжгүй байдлаас химийн бодисын бүрэн бүтэн байдал алдагдаж асгарах, уурших	Аюул осол тохиолдсон үед эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга зүйн дагуу тусламж үзүүлэх	200.000 төг	Хөдөлмөр хамгааллын ажилтан
Химийн бодис агуулсан тоосжилт, ууршилт хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	Гал түймэр, тэсрэлт, хортой бодис алдагдах гэх мэт гэнэтийн осол гарсан тохиолдолд авах арга хэмжээний шуурхай ажлын удирдамж төлөвлөгөөний дагуу ажиллах	750.000	үйлдвэрийн удирдлага, Хөдөлмөр хамгааллын ажилтан
Эмульсийн үл тэсрэх хольцын үйлдвэрт <i>Урвалж бодис найруулах Хортой аюултай бодис асгарах, алдагдах</i>	Аюул осол тохиолдсон үед эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга зүйн дагуу тусламж үзүүлэх	350.000 төг	Салбарын инженер, үйлдвэрийн оперотор
Ашиглалтын үед тохиолдож болох эрсдэл	Эрсдлийн дараа авах арга хэмжээ	Төсөв	Хариуцах эзэн
Ажилчдын санаандгүй болон болгоомжгүй үйлдлээс химийн бодисд өртөх, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бохирдох	Эрсдэлд өртсөн ажилчдыг эмчид хүргэх, эмчлүүлэх		Үйлдвэрийн удирдлага, Хөдөлмөр хамгааллын

эрсдэлтэй			ажилтан	
Ууршилт, асгарах, технологийн горим алдагдах	Эрсдэлд өртсөн байгаль орчны бүрэлдхүүн хэсгийн химийн бодисыг саармагжуулах аюулгүй болгох арга хэмжээ авах	600.000	Үйлдвэрийн удирдлага, хөдөлмөр хамгааллын ажилтан	
Нийт дүн		4.500.000		

9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын тухай хууль болон хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг баримталж ажиллах;

Үйлдвэрт 14 хүн ажилладаг бөгөөд өдөрт нэг хүн дунджаар 0,15 кг хатуу хог хаягдал гаргахаар тооцвол сард /ажлын 22 хоног дунджаар/ 92,4 кг ахуйн хатуу хог хаягдал гарах ба үүнийг ахуйн хатуу хог хаягдал цуглуулах цэгт цуглуулан гэрээний дагуу зайлуулагдах юм

Орон нутгийн байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулах, журам, нормативийн дагуу төлбөрийг төлж ажиллана.

Ажиллагсдын амрах байр /тамхи татах цэг/ болон ажлын байрны ойролцоо боломжтой бүх газруудад хог хаягдлыг ялган ангилах хогийн сав байршуулна.

Улбар шар – бүх төрлийн хуванцар хог хаягдал

Ногоон – лааз, шил

Хөх – бичгийн цаасны хаягдал

Хар – бусад хог хаягдал г.м. ангилан ялгалтыг хийнэ.



Хог хаягдлын төсөв

Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах тушаалтан	албан	Жилд
Ахуйн болон хатуу хог хаягдал	Сар болгон	Үйлдвэрийн мастер		6.960.000

Эмульсийн тэсрэх бодисийн үйлдвэрийн үе шат дамжлага бүр дээр чанарын шалгалт хийж чанарын үзүүлэлтүүд нь стандарт шаардлага хангасан бол дараагийн шат дамжлагад очно. Харин чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнүүд буцаж үйлдвэрийн өмнөх дамжланд ордог учир үйлдвэрээс гарах хог хаягдал байхгүй.

Ахуйн хатуу хог хаягдал: Ахуйн болон тусгай хог хаягдлыг зориулалтын хогийн цэг рүү тээвэрлэн хаяна. Үйлдвэрт нийт 30 ажилтантай жилийн 250 хоног, 2 ээлжээр 24 цагаар ажилладаг ба жилийн засварт зогсох хоног нь 14 хоногийн ажлын хувиартай байна. Пауэр бласт ХХК нь Гурван тэс сумын Хот тохижуулах газартай ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭГ хийнэ.

Пауэр Бласт ХХК нь Өсөх зоос ХХК-тай хийсэн гэрээний дагуу ажилчид нь төслийн талбайгаас 1.5 км зайд байрлах Өсөх зоос ХХК-ний кемпэд байрладаг тул ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдалыг зайлуулах, устгах арга хэмжээг тус компани хариуцдаг байна.

Шингэн хаягдал: Үйлдвэрээс шингэн хог хаягдал гарахгүй. Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг хуримтлуулах зориулалттай септик системийг хийж цэвэршүүлж хөрсөнд шингээнэ.

Хийн хаягдал: Хийн хог хаягдал гарахгүй.

Тусгай хог хаягдал

Эмульс үйлдвэрлэх процессын явцад үйлдвэрлэлийн хаягдал гарахгүй. Үйлдвэрлэлийн ажлын ээлж дууссаны дараа тоног төхөөрөмж, танк сав, шугам хоолойг тогтмол цэвэрлэнэ.

Аммиакийн шүүний шуудайг исэлдүүлэгчийн хоосон сав хадгалах талбайд хүргэж цуглуулаад дахин боловсруулах байгуулагад өөрийн тээврийн хэрэгсэлээр хүргэж өгнө.

Эмульгатор, үйлдвэрийн тосны хоосон төмөр торх зэргийг хоосон сав хадгалах талбайд хурааж хадгалаад хувиарын дагуу дахин боловсруулах цэг рүү явуулна.

10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн бүх үе шатанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах бүх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах удирдлагын нарийн тогтолцоог бий болгоход оршино. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулах хэрэгтэй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр баримталж ажиллах эрх зүйн баримт бичгүүдийн эмхэтгэлтэй болно. Үүнд:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажиллагсдлын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр баримталж ажиллах эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх

Баримталж ажиллах эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт болон заалтуудыг гаргах

Эрх зүйн баримт бичгүүдийг эмхэтгэл болгон бэлтгэж, гарын авлага хэвлүүлэх

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгож, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг сургалт сурталчилгааны тогтолцоо бүрдүүлэх;

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Төсөв
1	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт сурталчилгаа хийх, ажилчдад нярад буюу зааварчилгаа өгөх	Ажил эхлэхийн өмнө	300.000
2	Хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж шинэчилж байх	Жил бүр	500.000
3	Ажиллагсдыг ажил эхлэхийн өмнө болон ажил дуусах үед эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Жил бүр	2.000.000 төг

4	Орон нутаг, аймаг, нийслэл, улсын холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай нягт хамтарч ажиллах	Жил бүр	-
5	Тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэх олгох сургалтанд ажиллагсдыг шат дараатай хамруулах	Сургалт явагдах үед	500.000
Дүн			3,300.000

Нөлөөллийг бууруулах ажлын төсөв

№	Гарчиг	Хугацаа	Төсөв
1	Нөлөөллийг зайлуулах арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	1 жил	1.000.000
2	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1 жил	1.000.000

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа болон байгаль орчны сургалт суртчилгаа

№	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Төсөв
1	Компаний ажилтанд зориулсан	Ажил эхлэхийн өмнө болон улиралд нэг удаа	Үйлдвэрийн дарга	-
2	Орон нутгийн байгууллага, иргэдэд	Жилд 1 удаа	Үйлдвэрийн дарга болон ерөнхий менежэр	700,000

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

Агаарын чанар

Химийн бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх хортой нөлөөлөл нь агуулахын талбайн ойр орчимд байна. Их хэмжээтэй асгарсан тохиолдолд салхины чиглэлээс шалтгаалан ойр орчимд тархах боломжтой. Иймээс аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллана.

Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

№	Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
1	Химийн бодисын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны горим алдагдах, тээвэрлэлт буруу хийгдсэнээс химийн бодисын сав баглаа боодолд гэмтэл гарч асгарах, улмаар төсөл хэрэгжих талбайн ойр орчимд салхины чиглэлээс шалтгаалан 0.5 км тархах	Хамгаалах хамгийн сайн арга нь аюулгүй ажиллагааг мөрдөн ажиллах
2	Химийн бодис тээвэрлэдэг тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүрийн дутуу шаталтын хий нь агаар орчныг хорт хийгээр бохирдуулж болзошгүй.	Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогмтол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх. Тээврийн хэрэгсэлд хорт хийг бууруулах шүүлтүүр суурилуулах.

Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авч ажиллана.

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин	рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО ₃ , хүчил НСО ₃ , кальци Са, хлор Cl, кали К, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор В, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молебдин Mo, никель Ni, хар	Ундны усны цэгээс	Жилд 2 удаа буюу 4 болон 10 саруудад гүний уснаас дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	1. 20.0 мян.төг 2. 135 мян.төг **УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ	465.0 мян.төг	MNS 0900: 2005 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

	тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ.					
Хөрсөн бүрхэвч	Хөрсний механик бүрэлдхүүн, ялзмаг, кадми Cd, кальци Ca, зэс Cu, хүнцэл As, мөнгөн ус Hg, кобальт Co, никель Ni, хар тугалга Pb, сод Na, магни Mg, төмөр Fe, цинк Zn, сульфат SO ₄ , хүчил саармагжуулах	Ахуйн хог хаягдлын цэг орчмоос	Жилд 2 удаа буюу 4 болон 9 саруудад мониторингийн н цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Хөрсний механик бүрэлдхүүн, ялзмаг 20.0 мян.төг Хөрсний хүнд металлын шинжилгээний үнэ 45.0 мян.тө	195.0 мян.төг	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох

	<p>чадвар, хүчил үүсгэх чадвар ANP/AGP, чулуулгийн найрлага ABA, нийт сульфит Total Sulfur, ялгардаггүй сульфат S N-Ex, пиритийн сульфит P-Sulfur, pH</p>					
Агаарын чанар	<p>-Тоосжилт (PM10, PSM, PM25) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны Эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг,</p>	Ажлын байрнаас	<p>Жилд 2 удаа буюу 4 болон 9 саруудад мониторингий н цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.</p>	<p>Ажлын байрны агаар дах химийн дэгдэмхий ба ууршимтгай хорт бодисууд, CO, CO2, CH2O, NO2, SO2, O3, Pb, C20H12,</p>	750.0 мян.төг	<p>MNS4990:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS5063:2001. Ажлын байрны агаар. Озоны хэмжээг тодорхойлох спектрометрийн ба фотоколориметрийн арга. MNS0012-079: 1991. Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Ажлын</p>

	чийгшил болон физик бохирдлын түвшин Бохирдлын цэгэн эх үүсвэр (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO)			тоосжилт		байрны агаарт байгаа хар тугалгыг тодорхойлох арга
Ажилагсдын эрүүл мэнд	Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж ажиллана.	Улиралд 1 удаа				Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
Нийт дүн					1.410.0 мян.төг	

12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 10 дүгээр сарын 01-ээс 20-ний дотор БОМТ-г тайлагнах журмын 2-р хавсралтын дагуу гаргаж, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын бага овоо багын иргэдэд тайлагнана.

Нэр/Огноо	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
БОМТ Батлуулах												
БОМТ Тайлагнах												